

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн ГХБХБГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БУА-2022/7/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Булган аймаг 2022 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр Утас: 70342580 Цахим хаяг: Ankhubayard@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn</p> <p>Аудитор: З.Ганбаатар Утас: 70342495 Цахим хаяг: ganbaatarz@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	Error! Bookmark not defined.
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-3259
E-mail: bulgan@audit.gov.mn

2022.02.25 № 110

танай _____ ны № _____ т

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Г.ГАНБААТАР ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

D:/bichighereg/2022A4toot

006020214

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР



2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>52,836,360.56</u>	<u>59,105,141.56</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	52,836,360.56	59,105,141.56
351	Түүхий эд материал	7,780,780.00	10,772,180.00
35110	Тусгай зориулалттай материал	7,780,780.00	10,772,180.00
354	Хангамжийн материал	45,055,580.56	48,332,961.56
35410	Бичиг хэргийн материал	14,662,666.61	15,643,666.61
35420	Аж ахуйн материал	26,591,423.95	28,624,423.95
35430	Сэлбэг хэрэгсэл	372,000.00	372,000.00
35440	Түлш, шатах тослох материал	3,180,940.00	2,894,721.00
35470	Бусад хангамжийн материал	248,550.00	798,150.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>494,057,834.50</u>	<u>590,400,337.12</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	494,057,834.50	590,400,337.12
392	Биет хөрөнгө	474,470,501.34	569,810,337.04
39201	Барилга, байгууламж, орон сууц	409,423,075.72	409,423,075.72
39202	Хуримтлагдсан элэгдэл	-21,755,889.18	-36,259,815.30
39203	Авто-тээврийн хэрэгсэл	90,491,750.00	41,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-84,091,750.08	-10,650,000.12
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	331,468,818.07	278,166,051.79
39206	Хуримтлагдсан элэгдэл	-263,918,200.22	-126,500,466.07
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	37,049,572.41	35,353,052.71
39208	Хуримтлагдсан элэгдэл	-24,196,875.38	-20,721,561.69
393	Биет бус хөрөнгө	19,587,333.16	20,590,000.08
39301	Программ хангамж	3,210,000.00	2,380,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-3,092,666.84	-1,259,999.92
39303	Бусад биет бус хөрөнгө	19,470,000.00	19,470,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>546,894,195.06</u>	<u>649,505,478.68</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>546,894,195.06</u>	<u>649,505,478.68</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	546,894,195.06	649,505,478.68
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	427,169,483.31	427,169,483.31
51101	Өмч: - төрийн	427,169,483.31	427,169,483.31
512	Хуримтлагдсан үр дүн	22,075,525.18	127,947,566.85
51210	Өмнөх үеийн үр дүн	22,075,525.18	25,336,283.23
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	102,611,283.62
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	97,649,186.57	94,388,428.52
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>546,894,195.06</u>	<u>649,505,478.68</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	642,059,240.08	779,100,216.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	31,751,042.00	198,357,305.00
120	Нийтлэг татварын бус орлого	31,751,042.00	198,357,305.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	31,751,042.00	198,357,305.00

ГХБХБГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	30,373,042.00	20,712,277.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,378,000.00	177,645,028.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал		2,980,450.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	104,054,698.08	86,878,211.40
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	506,253,500.00	493,864,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	67,899,411.38	54,559,659.40
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	65,899,411.38	53,659,659.40
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,000,000.00	900,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	30,300,000.00	28,008,052.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	30,300,000.00	28,008,052.00
1330	Төсвийн захирагчдаас	5,855,286.70	4,310,500.00
133003	Хөрөнгийн	5,855,286.70	4,310,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	656,733,975.73	676,488,932.78
21	УРСГАЛ ЗАРДАЛ	656,733,975.73	676,488,932.78
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	551,348,489.81	583,529,584.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	380,220,293.36	373,247,377.60
210101	Үндсэн цалин	282,912,010.44	280,768,247.60
210102	Нэмэгдэл	79,354,133.39	76,290,321.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,996,500.00	9,954,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	8,957,649.53	6,234,809.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,250,697.10	45,652,616.28
210201	Тэтгэврийн даатгал	34,503,988.97	34,582,333.48
210202	Тэтгэмжийн даатгал	3,343,862.59	2,914,686.67
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,928,986.93	2,313,548.89
210204	Ажилгүйдлийн даатгал	834,984.57	572,438.08
210205	Эрүүл мэндийн даатгал	7,638,874.04	5,269,609.16
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,327,372.00	27,508,052.00
210301	Гэрэл, цахилгаан	2,440,130.00	1,633,452.00
210302	Түлш, халаалт	25,238,400.00	25,238,400.00
210303	Цэвэр, бохир ус	648,842.00	636,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,581,073.10	16,560,624.00
210401	Бичиг хэрэг	12,099,716.70	9,234,380.00
210402	Тээвэр, шатахуун	10,143,712.40	6,632,294.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	433,744.00	436,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	903,900.00	257,750.00
2105	Нормативт зардал	328,800.00	343,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	328,800.00	343,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	165,000.00	500,000.00
210604	Урсгал засвар	165,000.00	500,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,892,800.00	2,502,500.00
210702	Дотоод албан томилолт	3,892,800.00	2,502,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	235,552.00	242,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	87,052.00	94,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	148,500.00	148,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	66,346,902.25	116,972,714.38
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	30,911,000.60	27,831,049.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	1,125,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	35,435,901.65	88,016,665.38
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	105,385,485.92	92,959,348.52
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,052,600.00	14,223,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	12,318,300.00

**ГХБХБГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,052,600.00	1,905,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	29,361,047.54	15,884,883.12
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	29,361,047.54	15,884,883.12
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,499,628.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,499,628.00	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	72,472,210.38	62,851,165.40
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	30,373,042.00	62,851,165.40
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	42,099,168.38	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-14,674,735.65	102,611,283.62
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-14,674,735.65	102,611,283.62

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	427,169,483.31	97,649,186.57	36,750,260.83	561,568,930.71
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	427,169,483.31	97,649,186.57	36,750,260.83	561,568,930.71
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-14,674,735.65	-14,674,735.65
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	427,169,483.31	97,649,186.57	22,075,525.18	546,894,195.06
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	427,169,483.31	97,649,186.57	22,075,525.18	546,894,195.06
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	3,260,758.05	3,260,758.05
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	427,169,483.31	97,649,186.57	25,336,283.23	550,154,953.11
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	3,260,758.05	00.00	3,260,758.05
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	102,611,283.62	102,611,283.62
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	427,169,483.31	94,388,428.52	127,947,566.85	649,505,478.68

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	634,825,953.38	597,144,688.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	30,373,042.00	20,712,277.00
120	Нийтлэг татварын бус орлого	30,373,042.00	20,712,277.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	30,373,042.00	20,712,277.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	30,373,042.00	20,712,277.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	604,452,911.38	576,432,411.40
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	506,253,500.00	493,864,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	67,899,411.38	54,559,659.40
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	65,899,411.38	53,659,659.40

**ГХБХБГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,000,000.00	900,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	30,300,000.00	28,008,052.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	30,300,000.00	28,008,052.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	618,606,749.38	589,640,388.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	618,606,749.38	589,640,388.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	513,221,263.46	496,681,039.88
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	380,220,293.36	373,247,377.60
210101	Үндсэн цалин	282,912,010.44	280,768,247.60
210102	Нэмэгдэл	79,354,133.39	76,290,321.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,996,500.00	9,954,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	8,957,649.53	6,234,809.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,250,697.10	45,652,616.28
210201	Тэтгэврийн даатгал	34,503,988.97	34,582,333.48
210202	Тэтгэмжийн даатгал	3,343,862.59	2,914,686.67
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,928,986.93	2,313,548.89
210204	Ажилгүйдлийн даатгал	834,984.57	572,438.08
210205	Эрүүл мэндийн даатгал	7,638,874.04	5,269,609.16
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,327,372.00	27,508,052.00
210301	Гэрэл, цахилгаан	2,440,130.00	1,633,452.00
210302	Түлш, халаалт	25,238,400.00	25,238,400.00
210303	Цэвэр, бохир ус	648,842.00	636,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,254,334.00	14,334,600.00
210401	Бичиг хэрэг	4,759,890.00	4,415,400.00
210402	Тээвэр, шатахуун	11,820,600.00	8,857,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	433,744.00	436,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,240,100.00	625,600.00
2105	Нормативт зардал	328,900.00	343,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	328,900.00	343,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	473,000.00	500,000.00
210604	Урсгал засвар	473,000.00	500,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,892,800.00	2,502,500.00
210702	Дотоод албан томилолт	3,892,800.00	2,502,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	235,552.00	242,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	87,052.00	94,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	148,500.00	148,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,238,315.00	32,350,194.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	33,238,315.00	31,225,194.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	1,125,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	105,385,485.92	92,959,348.52
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,052,600.00	14,223,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	12,318,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,052,600.00	1,905,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	29,361,047.54	15,884,883.12
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	29,361,047.54	15,884,883.12
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	72,472,210.38	62,851,165.40
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	30,373,042.00	62,851,165.40
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	16,219,204.00	7,504,300.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	16,219,204.00	7,504,300.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	16,219,204.00	7,504,300.00
2200	Дотоод эх үүсвэрээр	16,219,204.00	7,504,300.00
223001	Бусад хөрөнгө	16,219,204.00	7,504,300.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-16,219,204.00	-7,504,300.00

ГХБХБГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	521,872,752.00	589,640,388.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	521,872,752.00	589,640,388.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	507,613,052.00	496,681,039.88
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	380,275,200.00	373,247,377.60
210101	Үндсэн цалин	282,143,000.00	280,768,247.60
210102	Нэмэгдэл	74,933,500.00	76,290,321.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,158,900.00	9,954,000.0
210105	Гэрээт ажлын хөлс	13,039,800.00	6,234,809.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51,337,200.00	45,652,616.28
210201	Тэтгэврийн даатгал	36,126,100.00	34,582,333.48
210202	Тэтгэмжийн даатгал	3,802,800.00	2,914,686.67
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,042,200.00	2,313,548.89
210204	Ажилгүйдлийн даатгал	760,600.00	572,438.08
210205	Эрүүл мэндийн даатгал	7,605,500.00	5,269,609.16
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,508,052.00	27,508,052.00
210301	Гэрэл, цахилгаан	1,633,452.00	1,633,452.00
210302	Түлш, халаалт	25,238,400.00	25,238,400.00
210303	Цэвэр, бохир ус	636,200.00	636,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,864,600.00	14,334,600.00
210401	Бичиг хэрэг	4,415,400.00	4,415,400.00
210402	Тээвэр, шатахуун	8,857,400.00	8,857,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	436,200.00	436,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,155,600.00	625,600.00
2105	Нормативт зардал	343,200.00	343,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	343,200.00	343,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	500,000.00
210604	Урсгал засвар	500,000.00	500,000.00
2107	Томилолт, зочны зардал	5,568,500.00	2,502,500.00
210702	Дотоод албан томилолт	5,568,500.00	2,502,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	242,500.00	242,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	94,000.00	94,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	148,500.00	148,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	26,973,800.00	32,350,194.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	25,848,800.00	31,225,194.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,125,000.00	1,125,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,259,700.00	14,223,300.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,259,700.00	14,223,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	12,318,300.00	12,318,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,941,400.00	1,905,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	7,504,300.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	7,504,300.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	521,872,752.00	542,585,029.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	493,864,700.00	493,864,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	493,864,700.00	493,864,700.00

1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	28,008,052.00	28,008,052.00
132001	Орон нутгийн төсвөөс	28,008,052.00	28,008,052.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	00.00	20,712,277.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	20,712,277.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		54,559,659.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ		54,559,659.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		12,420,771.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	12420771.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		12,420,771.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		42,138,888.40
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		42,138,888.40
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	54559659.40
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		54,559,659.40
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		53,659,659.40
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		900,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу ГХБХБГазрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Аудитор З.Ганбатаар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

ГХБХБГазрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 01/41 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

ГХБХБГазар нь “Салбарын хууль эрх зүй, техникийн баримт бичгийг боловсронгуй болгох, хэрэгжүүлэх, газрын шинэтгэлийн бодлогыг эрчимжүүлж, газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах, Монгол орны нутаг дэвсгэрийг зурагжуулах, солбицол, өндрийн нэгдсэн тогтолцоог хангах, үндэсний орон зайн мэдээллийн дэд бүтэц байгуулах” гэсэн эрхэм зорилгыг тавьж ажилласны хүрээнд 14 зорилтыг тавьж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Сумдын газрын даамлуудад хяналт-шинжилгээ хийх нэгдсэн удирдамжийг боловсруулан 2021 оны 5 дугаар сарын 17-ны өдөр Газрын даргаар батлуулсан.

Баян-Агт, Баяннуур сумын газрын даамал үүрэгт ажлаасаа чөлөөлөгдсөнтэй холбогдуулан 2021 оны газартай холбоотой үйл ажиллагааг хянан шалгаж, ажил хүлээлцэх актыг үйлдэн удирдлагуудад нь танилцуулан холбогдох зөвлөмжийг өгч ажилласан байна.

ГХБХБГазрын бүтэц орон тоонд дотоод аудит байхгүй бөгөөд дээд шатны төсөв захирагчийн санхүүгийн хяналт, дотоод аудитын хэлтэс 2021 онд төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

ГХБХБГазрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн нийт зардлын 656.7 сая төгрөгөөс 1 хувиар буюу 6.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 4.6 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

ГХБХБГазрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 102.6 сая төгрөгөөр буюу 18.7 хувиар өссөн нь тайлант онд тэг үлдэгдэлтэй үндсэн хөрөнгийг үнэлсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/Мян.төг /
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	
Авлага	0	0	
Урьдчилгаа	0	0	
Бараа материал	52,836,360.56	59,105,141.56	6,268,781.00
Үндсэн хөрөнгө	494,057,834.5	590,400,337.12	96,342,502.62
Нийт хөрөнгө	546,894,195.06	649,505,478.68	102,611,283.62
Өр төлбөр	0	0	
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	427,169,483.31	427,169,483.31	
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	546,894,195.06	649,505,478.68	102,611,283.62

Авлага: Тайлант онд авлага үүсээгүй тайлагнасан байна.

Бараа материал: Бараа материалын оны эхний үлдэгдэл 52.8 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 59.1 сая төгрөг болж өмнөх оноос 6.3 сая төгрөгөөр өссөн байна.

Тайлант онд 33.3 сая төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 28.2 сая төгрөгийн бараа материал худалдан авч, дээд шатны байгууллагаас үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 5.1 сая төгрөгийн материал тус тус нэмэгдэж орлогоор тусгасан байна.

Үндсэн хөрөнгө: Үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 891.1, тайлант онд төсвийн хөрөнгөөр 7.5, дээд шатны төсөв захирагчаас үнэ төлбөргүй шилжиж ирсэн 3.0, тэг үлдэгдэлтэй 89 төрлийн 289.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж, 173.8 сая төгрөгийн шинээр үнэлгээ тогтоож бүртгэлд тусгаснаар үндсэн хөрөнгө нэмэгдсэн байна.

Өр төлбөр: Тайлант онд өглөг үүсээгүй тайлагнасан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 610.6 сая төгрөгөөр, нийт зарлагыг 610.6 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс хэмнэлтийн горим хэрэгжүүлж 64.1 сая төгрөгөөр бууруулан 521.8 сая төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн урсгал үйл ажиллагааны арга хэмжээг хэрэгжүүлэхээр 521.8 сая төгрөгийн төсөв баталснаас 28.0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 493.8 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна. Үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэх эх үүсвэр батлагдаагүй байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 28.0 сая, тусгай зориулалтын шилжүүлгээс 493.8 сая төгрөгийн санхүүжилт авч үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоор 20.7 сая төгрөг, техник хяналтын орлогоор 42.1 сая төгрөг нийт 62.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 505.9 сая төгрөгийг зарцуулж 15.9 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлж 62.8 сая төгрөгийг дээд шатны байгууллагад нийт 78.7 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын барилгын техник хяналтын орлогоор 54.6 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс барилгын хяналтын инженер Н.Гүржавыг Аймгийн Засаг даргын 2017 оны 1-р сарын 25-ны өдрийн А/122 тоот захирамжийг үндэслэн байгууллагын даргын 2021 оны 2-р сарын 25-ны өдрийн Б/15 тоот тушаалаар хөдөлмөрийн гэрээ байгуулан нэмэлт санхүүжилтийн зардлаас цалинжуулахаар үргэлжлүүлэн ажиллуулах зардалд 12.5 сая төгрөгийг зарцуулж 42.1 сая төгрөгийг ГЗБГЗЗГазарт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

Аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй онцолсон бусад асуудал буюу Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотой дараах асуудлууд байна. Үүнд:

- Тайлант онд 915.0 мянган төгрөгийн тавилга хэрэгсэл худалдан авсан,
- Байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээний батлагдсан төсөвт хэмнэлт гараагүй.

3.8 Аудитын гол асуудал

Тайлан үеийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

ГЗБГЗЗГазар нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

2021 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар тус хуулийн 6 дугаар зүйлийн

6.4.1, 6.4.4, 6.4.5, 6.4.8, 6.10 дахь заалтад заасан мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ 6.4.7-д " байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт", 6.4.8-д "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр,"; 6.10-д "Шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбар, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг хавсаргасан байна." гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар нийт 0.9 сая төгрөгийн 3 алдаа зөрчил илэрснээс 0.9 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгсөн байна.

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт			Зөрүү	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь	Тоо	Дүн
Төлбөрийн акт	0	0	0	0	0	-	-
Албан шаардлага	0	0	0	0	0	-	-
Зөвлөмж	3	850.0	2	850.0	66.6	-	-
Нийт дүн	3	850.0	2	850.0	66.6	-	-

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитаар байгууллагад шилэн дансны мэдээллийг хуульд зааснаар хэрэгжүүлж байгааг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2.7 сая төгрөгийн 4 алдаа зөрчил илэрснээс, 1.0 сая төгрөгийн 1 алдааг залруулж, 0.8 сая төгрөгийн 1 төлбөрийн актыг тогтоож, 0.9 сая төгрөгийн зөрчилд таслан зогсоох 2 албан шаардлага өгч ажиллаа.

4.1 Залруулсан алдаа

Тайлант онд шатахууны зардлыг тооцооны дансаар дамжуулаагүй 1000,000.0 төгрөгийг шууд зардалд бичсэн нь НББ-ийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна." 15.2 дахь "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна." гэсэн заалтын дагуу залруулга хийсэн.

4.2 Төлбөрийн акт

Тээвэр шатахууны зардлаас анхан шатны баримтгүй зарцуулсан 767,647.0 төгрөгийн зарцуулалт хийсэн нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт

хийж баталгаажуулна.", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэсэн заалттай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн зохистой ба нийцтэй байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн байдал: Төлбөрийн акт тогтоосон.

4.3 Албан шаардлага

Тайлант онд Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.4 дэх заалтыг зөрчин 915,000.0 төгрөгийн тавилга хэрэгслийн зардалд зарцуулсан нь санхүүгийн тайлангийн аудитын зохистой ба нийцтэй байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн байдал: Албан шаардлага өгсөн.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг тулган баталгаажуулахад хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.4, 6.4.5, 6.4.8, 6.10 дахь заалтад заасан мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь тухайн хуулийн 4.1.1.мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх, 4.1.3.тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй.

Шийдвэрлэсэн байдал: Албан шаардлага өгсөн.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая.төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ГХБХБГазар	4	2.7	1	1.0	1	0.8	2	0.9		
	Нийт дүн	4	2.7	1	1.0	1	0.8	2	0.9		